

“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“АСБИ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн Баасан гаригт 11.00 цагт Улаанбаатар хот, АСБИ ХК-ны байранд зохион байгуулав. Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчээс 4 хувьцаа эзэмшигч оролцсон нь 59,670 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 94.03% болж байгаа тул Компанийн тухай хуулийн 69.1-т зааснаар ХЭХ хуралдуулах ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болсныг тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн мэдээлэв.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хараат бус аудиторын дүгнэлтийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
3. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2022 оны зардлын төсөв батлах

АСБИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурал:

Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, хурлын ирцийг Тооллогын комиссийн дарга Б.Доржсүрэн: -ХЭХ-ийн ирцийг танилцуулья.

Нийт 57 хувьцаа эзэмшигчээс 4 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна. Энэ нь нийт саналын 94.03% хувь болж байгаа тул хурал хүчин төгөлдөр болж байна.

Хэлэлцэх асуудал 1. -Компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт болон үйл ажиллагааны тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал 2. - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Гишүүдийн танилцуулгыг танилцуулж хүргүүлсэн байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Д.Лхагвасүрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Л.Сүмбанд 59670 ширхэг буюу 100%-ийн санал
3. Ч.Дашцэрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал

4. С.Буман-Эрдэнэ 59670 ширхэг буюу 100%-ийн санал
5. Б.Доржсүрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
6. С.Бат-Эрдэнэ 59670 ширхэг буюу 100%-ийн санал

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Э.Буянтогтох 59670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Ц.Хадаа 59670 ширхэг буюу 100%-ийн санал
3. Л.Нямдаваа 59670 ширхэг буюу 100%-ийн санал тус тус 100%-ийн санал өгсөн байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх заалт, СЗХ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй болж байна.

Хэлэлцэх асуудал 3. - Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2022 оны зардлын төсөв батлах

Энэ жилийн ТУЗ-ын төсвийг өнгөрсөн жилийн төсөвтэй ижил байхаар 8,000,000 сая төгрөгөөр батлуулахаар оруулсан байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хурлын тогтоол баталж, Хурлын дарга Д.Лхагвасүрэн дээрх дүгнэлтийг үндэслэн хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар ХЭХ-ын тогтоол тус бүрийг уншиж танилцуулан батлав.

Цаашид компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

Ийнхүү энэ удаагийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.ЛХАГВАСҮРЭН
С.БУМАН-ЭРДЭНЭ
Б.ДОРЖСҮРЭН

